

“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХЭ-ИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 25

Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурал 2023 оны 04-р сарын 25-ны өдрийн 11:00 цагаас “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай цахим хаягаар дамжуулан цахим хэлбэрээр болж, Хурлын даргаар Гүйцэтгэх захирал Б.Золбаяр, удирдлагын багаас Б.Хүдэртулга, Б.Алтанзул, М.Мөнхбаатар, Б.Одгэрэл, Ж.Даваасүрэн, ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн гишүүн Г.Саруул, ТУЗ-ийн гишүүн Б.Билэгт, Хараат бус гишүүн Э.Бямбажав, ТУЗ-н гишүүн Ш.Бэжид Тооллогын комиссын дарга Б.Мэндсайхан тооллогын бүрэлдэхүүн, Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ :

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2023 оны бизнес төлөвлөлтийг танилцуулах,
3. ТУЗ-ын үйл ажиллагааны зардлыг хэлэлцэн, гарах шийдвэрийн төслийн хамт батлах;
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, ТУЗ-д нэр дэвшигчдийг хурлаас гарах шийдвэрийн төслийн хамт танилцуулах;

Хурлын дарга: Хурлыг нээж үг хэлэн, Хурлын даргаар миний бие томилогдон ажиллаж байна. Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

-Хурлын дэгийг баталснаар танилцуулав.

-Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Тооллогын комисс ирцийг танилцуулна уу?

Б.Онон: Бодь Даатгал ХК-н ХЭЭХ-н тооллогын комиссын тогтоол 2023 оны 04 сарын 25-ны өдөр дугаар 1 Улаанбаатар хот. “Бодь Даатгал” ХК-ийн ХЭЭХ-д 207,200,847 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 30 хувьцаа эзэмшигч оролцож нийт саналын эрх бүхий 228,275,458 ширхэг хувьцааны 90,77 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дахь заалт, Компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 90,77 хувийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул ХЭЭХ-г хүчин төгөлдөр гэж тооцсугай.

Хурлын дарга: Баярлалаа, Хурлын дэгийн дагуу санхүүгийн үйл ажиллагааны тайлан мэдээллийн талаар хүргэе. 2022 оны үр дүнтэй холбоотой slide үзүүлэв. Даатгалын салбар өнгөрсөн 3 жилийн хугацаанд, 2022 онд 25%-н өсөлт үзүүлж нийт даатгалын салбарын цэвэр хураамж 186,1 т.б төвлөрүүлсэн үзүүлэлттэй байна. Инфляцаас үүдэлтэй нөхөн төлбөрийн өсөлт өмнөх жилтэй харьцуулахад салбарын хэмжээнд 37 хувийн өсөлттэй байна. Нөхөн төлбөр нэмэгдэхэд учирч болох хохирлын нөөц сан болон бусад 8 төрлийн нөөц сан нэмэгдэх зүй зохицолтой боловч салбарын хэмжээнд 2022 оны нөөц сан 10 %-р бууруулсан байгаа нь салбар ашигтай гарахад гол нөлөөлсөн гэж үзэж байна. Бодь Даатгал 2021 оноос хойш цэвэр хураамжаа жил дараалан 30-24%-р нэмэгдүүлж 23,6 т.б борлуулалтыг хийж салбарт цэвэр хураамжаар 2-т орсон үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч салбарын

хэмжээнд болон Бодь даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ эрс нэмэгдэж 36%-р нэмэгдсэн ба 14,6 т.б нөхөн төлбөр олгосон. Цэвэр нөөц сангаа 40%-р нэмэгдүүлсэн энэ нэмэгдсэн дүнгийн хэмжээгээр 1,4 т.б алдагдалтай гарсан. Цаашид бид өсөлтийн боломжоо ашиглахаас гадна нөхөн төлбөр, даатгалын үйл ажиллагаа ашигт ажиллагаа эрсдэлийн бодлогодоо илүү анхаарч ажиллахаар төлөвлөсөн. Орлогын үзүүлэлтийн хувьд цэвэр хураамж +24%-р, зардалд тооцсон нөхөн төлбөр +46%, давхар даатгалын шимтгэл -23%,-р буурсан. Та бүхэнд Орлогын тайлан, цаашдын төсөөллөө задалж үзүүлье. Ц.х 23,6 т.б үүнээс орлогот тооцсон хураамж 19,9 т.б хүрсэн энэ дүнгээс бусад зардлуудаа хасаад ашиг гарна гэж хэлж болно. 2022 оны төгсгөлд томоохон дүнтэй гэрээнүүд хийгдсэнтэй улбаатайгаар орлогод тооцсон хураамж бага байсан. Төлөвлөгөөнд тусгасан 21,5 т.б байсан 2 т.б бууралттай орлого тооцсон хураамжийг бүрдүүлсэн. Хохирлын харьцаа 62%, Ү.а зардлын харьцаа 45%, гэрээний зардлын харьцаа 15%-тай хосолсон харьцаа 122% тай буюу даатгалын үйл ажиллагааны ашиг -22% тай гарсан. Хосолсон харьцааг тооцоход зардалд тооцсон нөхөн төлбөр, ҮА зардлыг орлогод тооцсон хураамжид харьцуулсан. Бид 2023 ондоо өсөлтийн төлөвлөгөөгөө үргэлжлүүлж ажиллана. Нөхөн төлбөрийн өсөлтийг хязгаарлах, даатгалын үйл ажиллагааг ашигтай байлгах үйл ажиллагааг шат дараатай авч хэрэгжүүлэх ба оны эцэст 2 т.б-н ашигтай ажиллана гэж төлөвлөөд байна.

Нөхөн төлбөрийн хэмжээ 2021 онд 10,7 т.б, 2022 онд 14,6 т.б төгрөгөөр нэмэгдсэн. Салбартаа нөхөн төлбөрөөр тэргүүлдэг. 2022 оны ү.а товч танилцуулахад Байгууллагын даатгалын борлуулалт 7,4 т.б-12,8 т.б болж 74 %-р харилцагчдын тоо 27%-р тус тус нэмэгдсэн. Иргэд даатгалын хувьд 10 т.б төлөвлөгөөтэй ч 8,6 т.б төгрөг болж бууруулсан. ОУЭМ, дотоодын эрүүл мэнд, болон тээврийн хэрэгслийн даатгалын бодлого хатуурч хураамж нэмэгдсэн. Нийтээр дүгнэхэд цэвэр хураамжийн төлөвлөгөө 98%-р биелүүлсэн боловч нөхөн төлбөрийг төлөвлөсөн дүнгээсээ 3,1 т.б илүү олгосон. Үүнд сэлбэг хэрэгсэл, эмчилгээний зардлын инфляц гол нөлөө үзүүллээ. Үүн дээр арга хэмжээ авсан боловч тодорхой үр дүнд хүрсэнгүй. Даатгалын тохиолдлын тоо 27%-р өсөж цэвэр нөхөн төлбөр 34 %-р өссөн байна.

Бүтээгдэхүүнээр оны харьцуулалт болон борлуулалтын сувгаар оны харьцуулалтыг харуулав. ЖХ Даатгалын нийт багцын хэмжээг 12 хувиар бууруулсан, тээврийн хэрэгслийн даатгал 11%-р нэмэгдэж, эрүүл мэндийн даатгал 113 %-р өссөн байна. Хөрөнгө болон хариуцлагын даатгалын багцыг 29-62%-р нэмэгдүүлсэн. Иргэдийн даатгалын нийт борлуулалт -22% буурсан.

2023 оны санхүүгийн төлөвлөлт: Даатгалын хураамжийн нийт орлогыг 2023 онд тэргүүлэгчийн байр суурьт орохоор төлөвлөж байгаа. Цэвэр хураамжийг нэмэгдүүлж андеррайтингийн үр ашигтай уялдуулах замаар нөхөн төлбөрийн бодит зардлыг бууруулахаар төлөвлөсөн.

Хурлын дэгийн дагуу ТУЗ-с гарсан дүгнэлтийг нарийн бичгийн дарга уншиж танилцуулна уу. / Уншиж танилцуулав./

Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөгөөр 6,7 т.б-ын ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1,3 т.б –н алдагдалтай ажилласан байх энэхүү алдагдалд бүтээгдэхүүний үнийн өсөлтийн улмаас нөхөн төлбөрийн дүн тодорхой хэмжээнд нөлөөлсөн гэсэн тайлбарыг удирдлага өгсөн хэдий ч энэ нь хангалттай үндэслэл болохгүйгээс гадна эрсдэлийг удирдаж чадаагүй буюу даатгалын бүтээгдэхүүний хяналтыг сулруулсан, гүйцэтгэх удирдлагын багийн зүгээс бүтээгдэхүүний хохирлын харьцааг оновчтой түвшинд барих ажлыг цаг алдалгүй зохион байгуулж ажиллаж чадаагүй, хангалтгүй ажилласан гэж дүгнэж байна.

Хурлын дарга: Дэгийн дагуу Дүгнэлтийг батлах, ТУЗ-н үйл ажиллагааны зардлыг хэлэлцэж батлах байгаа.

Зардлыг харуулж танилцуулав. Та бүхэн санал шийдвэрээ цахимаар өгөх юм.

Мөн дэгийн дагуу дараагийн асуудал болох ТУЗ-н гишүүдийг сонгох байна. 11 гишүүдийн анкетыг танилцуулав.

Нийт 9 гишүүн сонгогдохоос 6 ердийн гишүүн 3 хараат бус гишүүнийг сонгох ёстой. Тооллогын комисс санал авах үйл ажиллагааг танилцуулна. Асуулт хариулт явуулъя.

Б.Онон: Санал авах дараалал болон санамж, санал хэрхэн өгөх зааварчилгааг нэг бүрчлэн тайлбарлан харуулж хэлэв.

Хурлын дарга: ТУЗ-н сургалтын зардлыг тусгасан байгаа энэ нь СЗХ-с засаглалын кодекс шинэчлэн баталсантай холбоотой сургалт хөгжлийн зардлыг тусгасан байгаа.

ТУЗ-н хурлаар ноогдол ашиг хуваарилахгүй байх тогтоол гарсан. Энэ нь 2022 онд компани алдагдалтай гарсантай холбоотойгоор ноогдол ашиг хуваарилахгүй байх шийдвэр гарсан, 2020-2021 онуудад ноогдол ашгаа хуваарилсан ба 2023 оноос үйл ажиллагаа ашигт ажиллагаанд ороод хуваарилах эсэх асуудлыг ТУЗ-ийн гаргах шийдвэрийн дагуу ажиллана.

Б.Онон: 10 мин хүлээж байгаад санал хураалтыг авъя.

Хурлын дарга: 12:10 -12:20 мин хүртэл санал авъя. ХЭ-ээс асуулт байвал хариулъя. Асуулттай холбоотой холбогдох газрын захирлууд бэлэн байгаа. Асуултыг ХЭХ линк дээр асуултаа илгээгээрэй. Саналыг хурааж дуусаад саналын дүнг тооллогын комисс танилцуулна.

Хурлын дарга: За хурлын дэгийн дагуу 10 мин завсарлага авъя.

Л.Болдхуяг: За би энэ бүхнийг ойлголоо, 2021-2022 онд Ковидтой жил байсан цэвэр хураамжийн үзүүлэлтээр 2-т жагсаж байсан байна их амжилттай ажиллаж байсан боловч алдагдалтай гарсанд сэтгэл дундуур байна. ХЭ-д бас ийм бодолтой байгаа байх, Бодь даатгал дандаа ашигтай ажиллаж ирсэн, ер нь тэгээд даатгалын компаниуд ашигтай гарсан харагдаж байна. Ноогдол ашиг олгохгүй байгаад сэтгэл дундуур байна. ТУЗ-н дүгнэлтийг та бүхэн харсан байх, гүйцэтгэх удирдлагуудад хариуцлага тооцох хүсэлт ТУЗ-д тавьсан. Үүнийг дэмжсэн, хуулийнд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэ алдааг дахиж битгий гаргаасай компанийн төлөө бүгд урагшаа гараасай, арагшаа битгий суугаасай, фронтоор ажиллах, удирдлагын баг дүгнэлт хийх биз. Гэрээгээ сайжруулж бүтээгдэхүүнээ сайжруулж хариуцлагатай ажилламаар байна. 2023 онд 6 сарын хугацаа өгсөн компанийг алдагдалгүй болгох ХЭ-дэд ноогдол ашиг тараах, ачлалтандаа хүрэхийг ХЭ бид хүлээж байна. Дараагийн ХЭ-н хурлаар баяртай сайхан мэдээ сонсож та бүхэн зөв зүйлд хөрөнгө оруулсан гэдгийг харуулах хэрэгтэй байна.

Б.Золбаяр: За ойлголоо.

Тооллогын комиссын дүнг хүлээе.

Тооллогын комиссын дарга Б.Мэндсайхан тооллогын шийдвэрийг танилцуулав.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 207,194,784 ширхэг хувьцаатай 24 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% зөвшөөрсөн, 0.0005% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
207,193,724	99.99%	1060	0.00%	0	0%

2. ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 207,194,784 ширхэг хувьцаатай 24 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0.0005% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
207,193,724	99.99%	0	0%	1060	0.00%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 207,194,784 ширхэг хувьцаатай 24 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Лувсанвандан БОЛДХУЯГ	14.07%	185,044,206.00
2	Ганбаатар САРУУЛ	14.03%	184,418,845.00
3	Болдхуяг БИЛЭГТ	14.03%	184,462,043.00
4	Ширчин СҮХБААТАР	14.03%	184,417,705.00
5	Шонуунорсон БЭЖИД	14.03%	184,417,029.00
6	Данзан ДАЯНБИЛГҮҮН	21.94%	288,420,404.00
7	Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ	7.88%	103,617,536.00
	Нийт	100%	

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Эрдэнэ БЯМБАЖАВ	38.94%	180,030,155.00
2	Батчулуун БҮЖИНЛХАМ	21.88%	184,417,706.00
3	Даваадаш МИНЖМАА	3.37%	15,961,666.00
4	Лхагвасүрэн БАНЗРАГЧ	35.80%	169,545,761.00
	Нийт	100%	

тус тус кумулятив санал авсан байна.

Дээрх нэр дэвшсэн гишүүдээс санал хураалтын дүнд дараах гишүүд ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдээр сонгогдов. Үүнд:

Ердийн гишүүнд:

1. Лувсанвандан БОЛДХУЯГ
2. Ганбаатар САРУУЛ
3. Болдхуяг БИЛЭГТ
4. Ширчин СҮХБААТАР
5. Шонуунорсон БЭЖИД
6. Данзан ДАЯНБИЛГҮҮН

Хараат бус гишүүнд:

7. Эрдэнэ БЯМБАЖАВ
8. Батчулуун БҮЖИНЛХАМ
9. Лхагвасүрэн БАНЗРАГЧ

Хурлын дарга: Хурлаас гарсан Тогтоолыг нарийн бичгийн дарга уншиж танилцуулна уу.

Ө.Батчимэг: Хурлын тогтоолын төслийг уншиж танилцууллаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “Хавсралт №1”-т заасны дагуу батлах,
2. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- Лувсанвандан овогтой Болдхуяг
- Ширчин овогтой Сүхбаатар
- Ганбаатар овогтой Саруул
- Болдхуяг овогтой Билэгт
- Шонуунорсон овогтой Бэжид
- Данзан овогтой Даянбилгүүн нарыг сонгохыг зөвшөөрөх,

Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- Эрдэнэ овогтой Бямбажав
- Лхагвасүрэн овогтой Банзрагч
- Батчулуун овогтой Бүжинлхам нарыг сонгохыг зөвшөөрөх,

3. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг “Хавсралт №1”-т заасны дагуу батлах,

Хурлын дарга: Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх асуудлууд дууслаа. Нийт Хувьцаа эзэмшигчид болон харилцагч та бүхэндээ баярлалаа хурал үүгээр өндөрлөж байна.

2023 оны 04-р сарын 25-ний 12:45 цагт өндөрлөлөө. Баярлалаа

Хурлын дарга :

Б.Золбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ө.Батчимэг

